



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Г Сүхбаатар дүүргийн 150 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 150 цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 120,326,885.00 (нэг зуун хорин сая гурван зуун хорин зургаан мянга найман зуун наян тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 150 дугаар цэцэрлэг (И.Нэргүй)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 11 нэр төрлийн 42,045,379.00 (дөчин хоёр сая дөчин таван мянга гурван зуун далан ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 7,509,600.00 (долоон сая таван зуун есөн мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 80,000.00 (наян мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 24,000 (хорин дөрвөн мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэх, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 4 нэр төрлийн 70,771,906.00 (далан сая долоон зуун далан нэгэн мянга есөн зуун зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сүхбаатар дүүргийн 150 дугаар цэцэрлэг (И.Нэргүй)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501052



Байгууллагын нэр: Нийслэлийн 150 дугаар цэцэрлэг

[illegible]

1	Хогийн сав	10	ш	2	250,000.00	500,000.00	500,000.00	-	Ашиглах боломжгүй гадна талбайн тохижилт шинээр хийгдэж байгаа	актлах	устгах	устгах	устгах
2	Сандаг	10	ш	5	350,000.00	1,750,000.00	1,750,000.00	-	Ашиглах боломжгүй гадна талбайн тохижилт шинээр хийгдэж байгаа	актлах	устгах	устгах	устгах
3	Тоглоом ком	10	ком	1	3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	-	Ашиглах боломжгүй гадна талбайн тохижилт шинээр хийгдэж байгаа	актлах	устгах	устгах	50,000.00
4	Тоглоом пивор	10	ком	4	1,000,000.00	4,000,000.00	4,000,000.00	-	Ашиглах боломжгүй гадна талбайн тохижилт шинээр хийгдэж байгаа	актлах	устгах	устгах	50,000.00
Бусад үндсэн хөрөнгийн дүн				12	4,600,000.00	9,250,000.00	9,250,000.00						
Үүнээс: Худалдах хөрөнгө				3		7,509,600.00							
Татан төвлөрүүлэх хөрөнгө				4		70,771,906.00							
Устгах хөрөнгө				11		42,045,379.00							
Худалдсанаас олох орлого													
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/												80,000.00	
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				1732	58,538,856.74	120,326,885.00	120,326,885.00						24,000.00